


ЧИНГИС ХААН БА МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН: ТҮҮХ, СОЁЛ, ӨВ



Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Японы, Ацүми олон улсын сан-Сэкигүчи олон нийтийн судлагааны нийгэмлэгтэй хамтран зохион байгуулсан Улаанбаатарын олон улсын 5 дахь симпозиумын хурлын эмхэтгэл “Чингис хаан ба Монголын эзэнт гүрэн: түүх, соёл, өв; Олон улсын эрдэм шинжилгээний V хурал 2012.07.24-26” хэвлэгдэн гарлаа.

Эдүгээ 5 дахь жилдээ зохион байгуулагдаж буй Улаанбаатарын олон улсын симпозиум нь Монгол-Японы харилцааны олон талт асуудлуудыг өнгөрсөн, одоо, ирээдүйн шүтэлцээн дунд авч хэлэлцэхийг эрмэлздэг билээ. Улаанбаатарын симпозиум энэ жил энэхүү уламжлалаа өөрчлөн Чингис хаан болон Монголын эзэнт гүрний түүх, өв уламжлалын асуудлыг хурлын хэлэлцэх сэдвээр сонгон авсан бөгөөд Чингис хааны мэндэлсний 850 жилийн ой, Монгол Японы хооронд дипломат харилцаа тогтсоны 40 жилийн түүхт ойд зориулснаараа онцлог юм. Уг хурлын эмхэтгэлд Монгол, Япон, ОХУ, Хятад, Их Британи, Солонгос, Тайланд зэрэг 10-аад орны эрдэмтэн судлаачдын Чингис хаан болон Монголын эзэнт гүрний талаарх тайлагдаагүй олон асуудлыг тодотгож, шинэ санал дүгнэлт дэвшүүлсэн 20 гаруй сонирхолтой илтгэлүүд багтсан болно.

ШИНЭ ЗУУНЫГ УГТСАН МОНГОЛ, ЯПОН



Монгол Японы хооронд дипломат харилцаа тогтсоны 40 жилийн ойг тохиолдуулан Монгол улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, МУИС-ийн Гадаад хэл соёлын сургууль, Япон улсын Монголын түүх, соёлыг судлах нийгэмлэг хамтран “Шинэ зууныг угтсан Монгол, Япон” гэсэн тодотголтой Монгол Японы залуу судлаачдын анхдугаар форумыг зохион байгууллаа. Энэхүү форумын зорилго

нь эрс хурдан өөрчлөгдөж буй Зүүн хойт Ази дахь нарийн төвөгтэй нөхцөл байдлыг харгалзан үзэхийн зэрэгцээ, уг бүс нутаг дахь нэгдэл болон олон талт зөрчил гэсэн өнөөдөр бодитойгоор оршин байгаа, нөгөө талаар түүхэн шинжтэй асуудлыг авч хэлэлцэн, шинэ зууныг угтсан Монгол Японы харилцаа чухам ямар үйл явцыг дамжин байж тогтон төлөвшиж ирсэн хийгээд цаашид хэрхэн хөгжвөл зохилтой эсэх асуудлын хүрээнд авч үзэж хэлэлцэхэд оршино. Хурлын илтгэл, хэлэлцүүлэг, эрдэмтэд судлаачдын санал санаачилгаар дамжуулан, Монгол Японы харилцаа, улмаар Зүүн хойт Азийн бүс нутгийн цаашдын хөгжлийн хэтийн төлөв, Монгол, Японы түүх, соёл, эдийн засаг, худалдааны судлагааг гүнзгийрүүлж, хоёр орны найрамдалт харилцааг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж байна.

Та бүхэнд Монгол, Япон, Солонгос, Хятад зэрэг орны залуу судлаачид оролцож, шинэ санал дэвшүүлсэн 20 гаруй илтгэл хэлэлцүүлсэн энэхүү форумын илтгэлийн эмхэтгэл “Шинэ зууныг угтсан Монгол, Япон” Монгол Японы залуу судлаачдын анхдугаар форум 2012.08.02-04”-ийг өргөн барьж байна.

Мэдээ бэлтгэсэн А.Сосорбурам
/ОУСХ-гийн ЭША/